



Хэрвээ та COVID-19 болон ханиад томуугаар хүнд өвчлөх өндөр эрсдэлтэй бол урьдчилан төлөвлөөрэй

Та COVID-19 болон ханиад томуугаар хүнд өвчлөх өндөр эрсдэлтэй юу?

Үүнд:

- 60 болон түүнээс дээш настай хүмүүс
- Жирэмсэн эмэгтэйчүүд
- Уугуул, Торрес Страйт Арлын болон Номхон Далайн Арлын иргэд
- Таргалалт, чихрийн шижин, зүрх судасны ноцтой эмгэг, архаг уушигны эмгэг (сүүлийн 12 сард эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүнд зэргийн астма орно), архаг бөгөөд хүнд элэг, бөөрний эмгэг мөн идэвхитэй хавдартай эсвэл дархлаа суларсан хүмүүс
- Хөдөлмөрийн бэрхшээлтэй хүмүүс ялангуяа уушиг, зүрх болон дархлалын системд нөлөө бүхий хөдөлмөрийн бэрхшээлтэй хүмүүс
- Өндөр настны болон хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэдийн асрах газрын оршин суугчид
- Дархлаажуулалтанд хамрагдаагүй 18 болон түүнээс дээш настай хүмүүс.

Хэрвээ та өвчилвөл эмч таны эдгэрэлтийг дэмжих зорилгоор вирусын эсрэг эм зөвлөж магадгүй.

Та энэ эмийг өвчилснийхөө дараа аль болох хурдан хугацаанд уух хэрэгтэй.

Танд вирусын эсрэг эм тохирох эсэхийг эмчтэйгээ одоо ярилцан, урьдчилан төлөвлөөрэй.

Хэрэв танд эрүүл мэндийн санаа зовнисон асуудал байгаа бөгөөд орчуулагчийн тусламж хэрэгтэй бол TIS-ийн **131 450** дугаарт залган Home Support Line, NSW Health Flu болон COVID-19 Care-ийн **1800 960 933** дугаарт холбож өгөхийг хүсээрэй.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.nsw.gov.au цахим хуудаснаас авна уу.